



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХАНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/114

Ханх сум

Мал, амьтны сэг зэм устгал, халдваргүйтгэлийн
ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.3.4, Захиргааны ерөнхий хуулийн 40.1, 40.2, 40.3, 40.4, аймгийн Засаг даргын 2024 оны 03-р сарын 25-ны өдрийн А/122 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Малын гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, отор нүүдэл, өвөлжилт, хаваржилтын хүндрэл болон зүй бусаар хорогдсон малын сэг зэгийг цуглуулж устгах, малын бэлчээр, бууц, хашаа байр, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн ажлыг 2024 оны 04-р сарын 10-ны өдрөөс эхлэн 05-р сарын 10-ны өдрийн дотор сумын хэмжээнд зохион байгуулсугай.

2. Ариутгал, халдваргүйтгэл, зэг зэм устгалын ажлыг дээрх хугацаанд хийж гүйцэтгэхийг "Мундрага" мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эзэн Б.Баясгалан, Тураг 1-р багийн Засаг дарга Ш.Отгонжаргал, Хороо 2-р багийн Засаг дарга Б.Анхбаяр, Турт 3-р багийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгч Э.Мөнхжаргал, Баясгалант 4-р багийн Засаг дарга Б.Бямбабаяр нарт үүрэг болгосугай.

3. Сэг зэм устгал, халдваргүйтгэлийн ажилд хамтран ажиллахыг Байгаль орчин, тогтвортой хөгжлийн бодлогын тасаг болон Хөдөө аж ахуйн тасаг, малчид, мал бүхий иргэдэд тус тус үүрэг болгосугай.

4. Ариутгал, халдваргүйтгэл, зэг зэм устгалын ажилд шаардагдах шатах тослох материал, хамгаалах хувцас хэрэгслийн зардлын тооцоог гаргаж шийдвэрлэхийг Засаг даргын тамгын газрын дарга (Б.Баасансүрэн)-д даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Э.Алтангэрэл)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л. ДАВААБАЯР

